

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

БУЛГАН АЙМАГ

2014.12.17

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО					
Зорилт 1.Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ.					
1.1	“Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /цаашид “ҮХЦБ” гэх/	Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-ий бодит өсөлт, хувиар	ДНБ 2014 онд урьдчилсан тооцоогоор 285.5 тэрбум төгрөгт хүрч 2013 онтой харьцуулахад 6.5 хувь буюу 18.7 тэрбум төгрөгөөр өссөн. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
			Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллороор	Нэг хүнд ногдор ДНБ 4сая 510 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 1.2 дахин өслөө. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
ХОЁР.БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
Зорилт 4.Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.					
4.1	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.2.10 дахь заалт	Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	Аймгийн төвийг нийслэл хоттой холбох хатуу хучилттай зам, км	Уньт-Тариалан чиглэлийн 88 км хатуу хучилттай авто замын хучилтын ажил дуусч, 10 дугаар сарын 1-нээс замын хөдөлгөөнийг нээж, 40 км замыг улсын комисст хүлээн авах ажилд орон нутгийн холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтэнгүүд сайдын тушаалаар томилогдон ажилласан. /Хэрэгжилт 90.0 хувь/	ХБХ
4.2	ЗГҮАХХАХТ-ний 109.1, 109.2 дахь заалт	“Гудамж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоол, 2014 оны 96 дугаар тогтоолоор “Гудамж” төслийг аймгийн төвүүдэд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний	ХБХ

				<p>дагуу Булган суманд “Гудамж” төслийг хэрэгжүүлэхээр ажлын даалгаврын төслийг боловсруулж, холбогдох баримт материалыг бүрдүүлэн “Гудамж” төсөлд хүлээлгэн өгсөн. “Гудамж” төслөөс зураг төсвийг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендер зарлагдсан.</p> <p>/Хэрэгжилт 100.0 хувь/</p>	
4.3	<p>“Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийн 2.25 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 220.3 дахь заалт</p>	<p>Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах</p>	<p>Тусгай замын автобусны дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар</p>	<p>Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааг хянах GPS системийг ашиглан, хот хоорондын зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянаж, зорчигчдын аюулгүй зорчих нөхцлийн бүрдүүлэн ажиллаж байна. 2014 онд ШҮГ-аас Дашинчилэн, Бугат, Гурванбулаг сумдад шуудан, зорчигч тээврийн үйлчилгээний шинэ чиглэл нээж, үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний үр дүнд аймгийн төвтэй Дашинчилэн, Бүрэгхангай, Орхон, Хишиг-Өндөр, Могод, Гурванбулаг, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг 10 сумд зорчигч, шуудан тээврийн үйлчилгээгээр холбогдоод байна. Аймгийн төвийн “Булган жолоо” ХХК, “Чимэгт Ундрэм” ХХК орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн авто үйлчилгээ, засварын газар шинээр байгуулагдан, тохирлын үнэлгээ хийлгэж, тохирлын гэрчилгээ олгосон. Аймгийн төвд нийтийн зорчигч тээврийн авто вокзал шинээр барих ажлын зураг төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж инженерийн шугам сүлжээний холболтын зураг төсвийг боловсруулах ажлыг Улаанбаатар хотын Форум-Арт ХХК-тай гэрээ байгуулан</p>	<p>ХБХ</p>

				гүйцэтгүүлж байна. Зураг төсөв боловсруулах ажил дуусч, улсын экспертизээр хянагдаж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	
Зорилт 6.Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ.					
6.1	ЗГҮАХХАХТ-ний 66.1, 67.2, 67.3, 67.5 дахь заалт	Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Шинээр барих дулааны цахилгаан станцын тоо	2011 оноос “Сэлэнгэ констракшн” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж эхэлсэн боловч санхүү, хөрөнгийн асуудлаас шалтгаалан дуусгалгүй орхисон дулааны станцыг барьж байгуулахад шаардагдах 3,0 тэрбум төгрөг, концессийн гэрээ байгуулах асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлсэн. Үүний үр дүнд одоогийн гүйцэтгэгч “Энержи плас” ХХК-ийн саналыг үндэслэн төр, хувийн хэвшлийн хүрээнд барих-ашиглах-өмчлөх нөхцөлтэйгээр гүйцэтгэх гэрээг Эрчим хүчний сайдтай байгуулж, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлсэн. Барилга угсралтын ажлын явцад Улсын Мэргэжлийн хяналтын газар, Эрчим хүчний үндэсний төвийн мэргэжилтэнгүүд ирж хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажиллалаа. Барилга угсралтын ажил 80,0 хувьтай байна. /Хэрэгжилт 90.0 хувь/	ХБХ
6.2	ЗГҮАХХАХТ-ний 66.4 дэх заалт	Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох	Байршлын тоо	Гурванбулаг сумын Рашаант, Бүрд, Жаргалант, Зүүн хорооны айл өрхийг эрчим хүчинд шинээр холболоо. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
Зорилт 7. Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.					
7.1	ЗГҮАХХАХТ-ний 5.7 дахь заалт	Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Дотор ханын хавтан, ламинатан шал, хуванцар хоолойн үйлдвэр	Булган сумын барилгын материалын үйлдвэрлэлийн бүсэд Орхон аймгийн “Билгүүнжин” ХХК - ны тоосго, явган замын	ХБХ

			байгуулах ажлын явц, хувиар	байгуулах ажлын явц, хувиар үйлдвэр байгуулах төсөлд 1.4 га газар, Улаанбаатар хотын "ОМДА" ХХК бетон сүлжээний зөвхөөрөнд, тусгай зориулалттай үйлдвэрүүд, тусгай зориулалттай зөвхөөрөнд төсөлд 1 га газрыг тус тус олгож, Билгүүнжин ХХК нь тоног төхөөрөмжөө суурьлуулж үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлж, Булган сумын "Нүнжигт өргөө" ХХК нь Хүрмэн чулуун блок үйлдвэрлэж эхэллээ. Орхон сумын Сээрийн үйлдвэрлэлийн бүсэд "Өрнөлт дүгнэн хоршоо"- керамик тоосгоны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурьлуулж тоосго үйлдвэрлэж эхэллээ. Хялганат тоосгоны "Зогсолтгүй хурд" ХХК 1.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий шахмал хавтангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурьлуулж байна. Тус үйлдвэр ашиглалтад орсоноор 600-900 ширхэг хавтан үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх бөгөөд ингэснээр гадагшаа зах зээлрүү гарч буй 9.2 сая. ам. Долларын урсгалыг багасгаж жилдээ 4.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийх боломж бүрдэх юм. /Хэрэгжилт 90.0 хувь/	
Зорилт 8.Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.					
8.2	ҮХЦБ-ын 5.2.1.2.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 30.1 дэх заалт	Арьс шир, ноос, ноолуур, оёмол, сүлжмэл, мах сүүний чиглэлийн боловсруулах аж үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжин хөгжүүлэх	ДНБ-д эзлэх боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувь	Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2014 оны эхний 10-р сарын байдлаар 13079.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6250.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт 6 дахин, борлуулалт 181.9 хувиар тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад уул уурхайн олборлох салбарын үйлдвэрлэлт 0.6 дахин	ХБХ

				буурсан бол дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 1.9 дахин, боловсруулах аж үйлдвэр 2.6 дахин тус тус өссөн ба нийт борлуулалтыг дотоодын зах зээлд борлуулсан байна. Нийт борлуулалтын 55.5 хувийг үр тарианы гурил, цардуул, малын тэжээл, 38.1 хувийг дулааны эрчим хүч усан хангамжийн салбарт борлуулсан бол 6.4 хувийг бусад салбарын борлуулалт эзэлж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/	
8.5	ЗГҮАХХАХТ-ний 93.11, 97.1, 97.3 дахь заалт	Үр тариа болон жимс, жимсгэний ургацыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх	Алим, гүзээлзгэнэ, чавга, интоор тариалах талбайн хэмжээ, мян.га	Алим, гүзээлзгэнэ, чавга, интоор тариалах 5 га-ийн плантаци байгуулах төсөлд 2 сумын 3 иргэн хамрагдаж тус бүр 10,0 сая төгрөгийн зээл авсан ч, энэ нь хашаа барих цөөн тооны суулгац худалдан авахад л зарцуулагдсан байна. /Хэрэгжилт 10.0 хувь/	ХБХ
			Ургацын хэмжээ, мян.тонн	2010 онд байгуулсан жимсний талбайгаас 92,14 тн жимс хурааж авсан. Ургац хураалтын эцсийн дүнгээр 32475 га-д үр тариа, тариалж, үр тариа 47,6 мянган тн буюу нэгжээс 15.3 цн, хураан авсан нь хүн амын тоонд харьцуулахад аймгийн хүн амын гурилын хэрэгцээг 140-хувиар хангаж байгаа дүн гарсан. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
Зорилт 9. Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.					
9.1	ЗГҮАХХАХТ-ний 82 дахь заалт	Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх "Аялал жуулчлал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр батлагдаагүй. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, маршрутыг боловсруулан ИТХ-ын 09 сарын 09-ний 134 тоот тогтоолоор батлууллаа. /Хэрэгжилт 100.0 хувь/	НХХ
9.2	ЗГҮАХХАХТ-ний 82 дахь заалт	Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, өрсөлдөх чадварыг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, сурталчилах зорилгоор "ITM-	НХХ

		дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх		2014” олон улсын үзэсгэлэнд 53 иргэн аж ахуйн нэгжийг оролцууллаа.Мөн Аймгийн аялал жуулчлалын маршрутыг боловсруулан гаргалаа. Хутаг-Өндөр сумын Хантай багийн Хангинахын шугуйд “Шагайн тойром”-ыг хийж эвент болгон зарлаж бүтээгдэхүүний тоог нэмэгдүүллээ. /Хэрэгжилт 100.0 хувь/	
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
Зорилт 10. Орчны бохирдлоос хамгаалж, доройтлыг бууруулж, ногоон хөгжлийг бий болгоно.					
10.1		“Саарал” усыг эргүүлэн ашиглахтай холбогдсон норм, стандартыг батлуулах	Норм, стандартын тоо	Эрдэнэт үйлдвэр ХХК хаягдлын аж ахуйгаас технологийн зориулалтаар 70 сая м3 ус, Бүрэгхангай сумын алт олборлогч аж ахуйн нэгжүүд хаягдал усны сан байгуулан эргүүлэн ашиглаж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
Зорилт 11.Биологийн олон янз байдлыг хамгаална.					
11.1	ЗГҮАХХАХТ-ний 232.1-232.4 дэх заалт	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх	Өргөтгөх хэмжээ, сая.га	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөөг батлуулан сумдын Засаг дарга нар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Аймгийн газрын нэгдмэл сангийн 18,8 хувь буюу 923127 га газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт аваад байна. Байгаль орчин, ногоон хөгжлийн яаман дээр хэрэгжиж буй "Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ" төслийн хүрээнд "Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэх" гэрээт ажилд холбогдох мэдээлэл, судалгааг	ХБХ

				гарган өгч, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. /Хэрэгжилт 100.0 хувь/	
11.2	ЗГҮАХХАХТ –ний 234.9 дэх заалт, “Нэн ховор амьтныг хамгаалах” хөтөлбөр	Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нэн ховор, ховордсон амьтдын эрсдэлийн үнэлгээ хийх, сэргээн нутагшуулах, үржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Эрсдэлийн үнэлгээ	2013 онд хийгдсэн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны ажлаар нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийлгэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг үндэслэж 2014 онд аймгийн агнуурын нөөц бүхий 8 сумын /Баян-Агт, Бугат, Могод, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр/ нутаг дэвсгэрт нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийлгэх тендер зарлагдаж байгаль орчны мэргэжлийн байгууллага “Амьтан асралт” ХХК шалгарч сумдын агнуурын бүс нутгийг тогтоон менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлаж, хариуцах нөхөрлөлийг сонгон сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлууллаа. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
			Гаршуулан үржүүлэх төрөл зүйлийн тоо	Хөгнө-Тарны ТХГНутагт аргаль хонь нутагшуулснаар 34 тоо толгойтой болж өссөн байна. Орхон аймгийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК нь Хангал сумын "Сэлэнгэ" амралтын бааз дахь Алтан тэгшийн аманд Хустайн нуруунаас 2010 оноос хойш бугын илий авчирч нутагшуулан одоо 43 толгой буга, согоо, илий болж өссөн байна. Хангал сумын Ёлын аманд 50 тарвага сэргээн нутагшуулж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХБХ
11.3	ЗГҮАХХАХТ-ний 234.2 дахь заалт	Устах аюулд орж байгаа ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах, генофондыг бий болгох	Нөхөн сэргээх талбай бүхий газрын тоо	Аймгийн хэмжээнд ургаж буй нэн ховор, ховор болон ашиглалтанд өрөмтгий ашигт ургамлын тооллого судалгааг явуулах ажлын тендерийн зарлан “Глобус” ХХК шалгаран бэлтгэл ажил болон хээрийн судалгааны ажлыг дуусаж	ХБХ

				<p>боловсруулалтын ажлыг гүйцэтгэж аймгийн ИТХуралд танилцуулахад бэлэн болоод байна. Орон нутгийн хамгаалалтанд орсон Баян-агт, Тэшиг суманд ургадаг нэн ховор ургамал болох “Заан хүж”, “Шудаг өвс”, “Бүрнүүс”, “Дүмбэрэй”, “Эмийн бамбай”-г идэвхтэн байгаль хамгаалагч ажлуулан хамгаалж байна. Булган сумын “Заан хүж” нөхөрлөл нь Баян-агт сумаас Заан хүжийг Бугат суманд нутагшуулан ургалт нь 70%-тай ургаж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.					
12.1	ЗГҮАХХАХТ-ний 127.2 дахь заалт	Аймгийн төвүүдийг хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх аймгийн тоо	<p>“Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж”-МОН/13/302 төслөөр Бүрэгхангай суманд бохир ус, ариутгах татуургын шугам сүлжээ, цахилгаан эрчим хүчний дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, Тэшиг суманд бохир ус, ариутгах татуургын шугам сүлжээ, нийгмийн үйлчилгээний барилгуудын дотор сантехникийн угсралтын ажил хийгдэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бүрэгхангай, Тэшиг сумын дулаан, цэвэр усан хангамж, усан сан. насос станц барих ажил хийгдэж байна. Гэрээний дагуу 2015 онд ашиглалтад орно. /Хэрэгжилт 90.0 хувь/</p>	ХБХ
12.2	ЗГҮАХХАХТ-ний 141.1 дэх заалт	“Сум” төслийг хэрэгжүүлж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>Монгол улсын 2014 оны Төсвийн тухай хуулийн ХҮ.1.58-д тусгагдсан 16 аймгийн тус бүр нэг суманд хэрэгжүүлэх “Сумын төвийн шинэчлэл” төсөлд манай аймгийн Хутаг-Өндөр сум хамрагдаж, аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн. Уг ажлыг хэрэгжүүлэхээр Улаанбаатар хотын “Эрхэт наран” ХХК-тай</p>	ХБХ

				гэрээ байгуулан, төслийн хүрээнд 4310 дулаан, цэвэр усны шугам, 2180 бохирын шугам болон бохирын систем, халаалтын барилгын засвар, сумын төвийн тохижилтын ажлууд хийгдэж байна. /Хэрэгжилт 70.0 хувь/	
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
Зорилт 13 ."Ажилтай, орлоготой Монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ.					
13.1	ЗГҮАХХАХТ-ний 145.2 дахь заалт	Түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал олгох	Дэмжлэг, урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл дэх ажлын байрын тоо	Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчийг урамшуулах, 40-өөс дээш насны ажилгүй иргэдийг ажлаар хангасан ажил олгогчийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж 40-өөс дээш насны ажилгүй иргэдээс ирүүлсэн нийт 20 төслийг хүлээн авч нийт 86 иргэнийг хамруулан 18,1 сая төгрөгний хөрөнгийг зарцууллаа. Ажил олгогчийг дэмжих урамшуулал болон санхүүгийн дэмжлэгт 5 ААН, 1 иргэнд 25.2 сая төгрөгийг олгов. /Хэрэгжилт 100.0 хувь/	НХХ
Зорилт 15.Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.					
15.2	ЗГҮАХХАХТ-ний 150.3 дахь заалт	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан, хөтөлбөрийг бий болгох	Малчдын хамрагдалтын хувиар	Хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн татварын хэлтсээс улирал бүр татварын албанд бүртгэлтэй ААНБ-ын жагсаалтыг авч шимтгэлийн баазтай тулган ажил олгогчийг шинээр бүртгэн ажилласнаар татварын албанд бүртгэлтэй нийт ААНБ –ийн 85.7 хувийг нийгмийн даатгалд хамруулсан 2014 онд 65 ААН, байгууллагын 165 даатгуулагчийг заавал даатгалд, 986иргэнийг сайн дурын даатгалд шинээр бүртгэснээр оны эхэнтэй харьцуулахад ажил олгогч 10.9 хувиар, заавал даатгуулагч 8,7 хувиар сайн дурын даатгуулагчдыг 51.2 хувиар тус тус	НХХ

				нэмэгдүүлж ажилласан байна. Энэ онд 4716 малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. /Хэрэгжилт 100.0 хувь/
Зорилт 16.Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.				
16.1	ЗГҮАХХАХТ-ний 194 дэх заалт	Боловсролын байгууллагын олон улсын солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдах багшийн тоо	Боловсролын байгууллагын олон улсын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж Япон улсад 4, БНСУ-д 4 багш нийт 8 багш хамрагдлаа. /Хэрэгжилт 70.0 хувь/
16.2	ЗГҮАХХАХТ-ний 187.3, 187.4 дэх заалт	Олон улсын жишигт нийцсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, арга зүй, технологийн шинэчлэл хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль, Хишиг-Өндөр сумын бүрэн дунд сургууль нийт /19+8/ бүгд 27 бүлэгт туршилт хийгдлээ. Бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх ажлыг манай аймгийн 2 сургууль амжилттай хэрэгжүүлж байгаа нь БШУЯ-аас болон мэргэжлийн байгууллагын удаа дараагийн мониторингийн дүгнэлт, үнэлгээ сайн хэрэгжиж байна гэсэн үнэлгээг өгч Булган сумын ЭӨЦС туршилтын үйл ажиллагааны тайлангаа иргэд олон нийтэд сурталчилан үр дүнгээ тайлагнах ажлыг зохион байгууллаа. 2014-2015 оны хичээлийн жилд Бага боловсролын хичээлийн шинэчилсэн цөм хөтөлбөрийг аймгийн бүх ЕБС-д хэрэгжүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/
		Цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	Ээлжийн болон туслах багшийн тоо	. Аймгийн Боловсролын чанарын шинэчлэл хөтөлбөрийг иргэд олон нийт болон аймгийн “Игэдийн танхим”-аар хэлэлцүүлэн саналыг нэгтгэн хөтөлбөрийн төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/
		Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх	Олон улсын солилцоо	2013-2014 оны хичээлийн жилд “Хүүхэд нэг

		арга зүй технологийг багшид эзэмшүүлэх "Багшийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	үндэсний сургалтад хамрагдах багшийн тоо	бүрийг хөгжүүлэх арга зүй технологийг багш нарт эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа. "Хүүхэд нэг бүрийг сургах арга зүй" чиглэлээр аймгийн сургагч багш нарыг бэлтгэлээ. Хишиг-Өндөр өндөр сумын сургууль Лаборатори сургууль болсноор аймгийн хэмжээнд 2 сургууль олон улсын стандартыг туршин бусад сургуулиудад нэвтрүүлэх загвар сургууль боллоо. Лаборатори сургуулиудын бага ангийн багш нарыг 2 удаагийн сургалтад хамрууллаа. Сургууль цэцэрлэг бүр Багшийн хөгжил, "Авьяас", "Ном" хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	
Зорилт 17.Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.					
17.1		Хүүхэд бүрийг авьяаст нь тулгуурлан хөгжүүлэх "Авьяас" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Секц, дугуйлан хичээллэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдах сургуулийн тоо	Сургууль цэцэрлэг бүр Багшийн хөгжил, "Авьяас", "Ном" хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна . "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд БШУЯ-наас Булган сумын 1-р сургууль, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны ЕБС тус бүрт олгосон 10.0 сая төгрөг олгож хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын техник хэрэгсэл шинээр худалдан авлаа. 2013-2014 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 18 сургуулиуд дээр 5-30 төрлийн дугуйлан хичээллэж, 6719 сурагч хамрагдсан байна. Нийт хүүхдийн 72,9% хамрагдсан байна. "Авьяас" хөтөлбөрийг хэрэгжүүлж сургууль бүр өөр өөрийн	НХХ

				онцлогтой олон төрлийн ажлыг зохион байгуулан зарим ажлыг дэмжиж ЕБС-ууд нийт 57.687.600 төгрөг зарцуулсан байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	
17.2	ЗГҮАХХАХТ-ний 187.7, 192.3 дахь заалт	Хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Шинээр бүтээх хүүхдийн номын тоо	Сургууль цэцэрлэг бүр “Ном” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна Ном хөтөлбөрийг 4 үе шаттай хэрэгжүүлэн сурагчдын бүтээлээр аймгийн ном хэвлүүлэн БШУЯ-нд хүргүүллээ. Аймгийн хэмжээнд 360 дугуйлан секцэд, 284 багш давхардсан тоогоор 8140 хүүхдийг хамруулан ажиллаж байна 2013-2014оны хичээлийн жилд нийт 34031493 төгрөг зарцуулж, нийт 19 сургууль, 23 цэцэрлэгийн сурагчдаас 270 нь фото, 350 сурагч эсээ, 3360 сурагч уран уншлага, 96 сурагч илтгэл, 333 сурагч гар зураг, 53 сурагч захидал, 23 сурагч өгүүллэг бичиж оролцлоо. Нийт 4485 сурагч бүтээл туурвисан байна. Том, жижиг ном бүтээхэд 3360 сурагч, 840 эцэг эх, 252 багш оролцлоо.Ном унших арга зүйн сургалтад давхардсан тоогоор 4200 эцэг эх, 20900 сурагч хамрагдсан байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	НХХ
			Ангийн номын сан байгуулах сургууль, цэцэрлэгийн бүлгийн тоо	ЕБС,-ийн 140 бүлэг, 20 цэцэрлэг Ангийн номын сан байгуулаан ажиллаж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/	НХХ
			Цахим сургалтын үндэсний төвийн тоо	Интернэтэд холбогдсон сургуулиудыг түшиглэн тэдгээрийн мэдээлэл харилцааны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадалд тулгуурлан сургалтыг цахим	НХХ

				<p>хэлбэрээр явуулах судалгаа, тооцоог хийж байна. Хишиг-Өндөр, Рашаант сумын сургуулиуд “Цахим самбар”-тай болж сургалт зохион байгуулж байна. Булган сумын ЭӨЦС, 1 дүгээр бүрэн дунд сургуулийн бага ангийн багш нар сургалтын цахим хэрэглэгдхүүн боловсруулан “Хөдөөгийн бага боловсролын хөгжүүлэхэд цахим хэрэглэгдхүүн ашиглах нь” бүсийн уралдаанд оролцон тэргүүн байр эзэлж техник хэрэгслээр шагнагдлаа. Мэдээлэл харилцааны чадамжийг дээшлүүлэх үндэсний төв”-тэй хамтран бүх сургууль, цэцэрлэгийг цахим хуудастай болголоо. Аймгийн хэмжээнд нийт сургуулиудын 84.0 хувь нь интернэтэд холбогдсон, 89.0 хувь нь албан ёсны цахим хаягтай, 42.0 хувь нь фэйсбүүк хаягтай боллоо. Могод, Тэшиг, Хангал, Бүрэгхангай сумдын цэцэрлэг, сургуулиудтай үүрэн холбооны операторын модемоор байнга холбогдон ажиллаж байна. 23 цэцэрлэгийн 73.9 хувь нь интернэтэд холбогдлоо. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-тай хамтран 8 сумын сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд холболоо.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
17.3	ЗГҮАХХАХТ-ний 205.1-205.6 дахь заалт	Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг тогтолцооны хэв шинжид оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, үнэлгээг сайжруулж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн мэргэшүүлж, давтан сургаж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг	Шинээр боловсруулах журам	<p>НХҮХ, БСГ, ЭМГ, ХГБХХ-тэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аймгийн зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 2-16 насны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж, Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн халамж үйлчилгээний газрын хамтарсан ажлын хэсэг байгуулан оношлогоо хийх ажлыг зохион байгуулж дүнг нэгтгэлээ. 16 сум, 1 тосгонд</p>	НХХ

		боловсронгуй болгох		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношлогоог хийхэд 2,8 сая төгрөгийг аймгийн Хөгжлийн сангийн хөрөнгөнөөс санхүүжүүллээ. 2013-2014 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 37, ЕБС-д 203 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн ангид суралцаж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/	
			Мэргэжлийн ажилтны тоо	2013-2014 оны хичээлийн жилд ХБХ-тэй ажиллах онол арга зүйн сургалтыг зохион байгуулж СӨБ-ын багш 22, Бага ангийн 34 багш нийт 56 багшийг хамруулсан. Мэргэжлийн багтай хамтран сургалт зохион байгууллаа. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтаас /БМДИ/-ээс зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад Боловсролын газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, бага ангийн 2 багш, цэцэрлэгийн 2 багш, нийт 5 хүн шинээр сургагч багшаар бэлтгэгдсэн. 2014 онд сургууль, цэцэрлэг тус бүрээс 1 хүнийг нийт 45 багшийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтанд хамруулж сургагч багшаар бэлтгэлээ. /Хэрэгжилт 90.0 хувь/	НХХ
17.4	ЗГҮАХХАХТ-ний 187.9, 187.12, 187.13 дахь заалт	Насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, олон нийтийн хандлага, төлөвшлийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2013-2014 оны хичээлийн жилд Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагдах суралцагчдын тоог шинэчлэн гаргаж 2013-2014 оны хичээлийн жилд насан туршийн боловсролын сургалтанд 343 хүн суралцснаас 73 иргэн суурь боловсролын гэрчилгээ, 82 иргэн бүрэн дунд боловсролын үнэмлэх авлаа. /Хэрэгжилт 70.0 хувь/	БШУЯ
17.7	ЗГҮАХХАХТ-ний 193.1 дэх заалт	Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлэх	Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлт, хувиар	“Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний систем” зохиогдож туршигдаж	БШУЯ

				<p>эхлээд байна. Уг систем ашиглалтад орох үед аймгийн багш ажиллагсадын мэдээллийг оруулахад бэлтгэж байна. Аймгийн хэмжээнд мэдээллийн технологийн суурь дэд бүтцийг бий болгох, бүрдүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын тушаалаар боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг боловсруулах, турших, сургалт зохион байгуулах ажлын хэсэг, байгуулж үйл ажиллагааны чиглэлийг гарган ажиллаж байна. 2014 оны 8 сард ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын менежерүүдийг Боловсролын газар дээр “Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний систем” нэвтрүүлэх сургалтад хамрууллаа. “Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний систем”-ийг сургууль бүр байгуулж сургуулийн нийт багш, ажилтан, суралцагчийн мэдээллийг оруулж дүнг Боловсролын газарт нэгтгэж байна. /Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
Зорилт 19. Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээг иргэн бүрд хүргэх боломжийг бүрдүүлнэ.					
19.2	ЗГҮАХХАХТ-ний 170.2 дахь заалт	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>“Сумын Эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг боловсруулан аймгийн ИТХ-ийн 88-р тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумдын эрүүл мэндийн төвүүд нь харьяалалын хүн амын 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настангуудад анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэн 4 удаа тойрон эргэлтээр явж, дархлаажуулалт, витаминжуулалт, идэвхтэй эргэлт, хяналтыг хийж, зөвлөгөө</p>	НХХ

				<p>зөвлөмжийг өгч ажиллаж байна. Орон нутагт нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг аймгийн Засаг даргын нэрэмжит “Нүүдлийн амбулатори” хэлбэрээр зохион байгуулж, үзлэгийн график, төлөвлөгөөг боловсруулан, хуваарийн дагуу 16 сумын 7350 иргэдэд дотор, мэдрэл, эх барих эмэгтэйчүүд, шүд, эхо, ДОХ БЗДХ, хүүхдийн чиглэлээр оношлогоо, шинжилгээ хийж 196 хүн шинээр оношлогдож үүнээс 101 хүнийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлж, 185 хүнийг сумдын ЭМТ-ийн эмчийн хяналтанд авч, нийт 2754 иргэнд сургалт сурталчилгаа хийж, НҮЭМ болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>/Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
19.4	ЗГҮАХХАХТ-ний 177.1 дэх заалт	Эмнэлгийн яаралтай тусламжийн хүрээг өргөтгөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>“Аймгийн Нэгдсэн эмнэлгийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” /2014-2016 он/-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 87дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээний улс, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгуулагуудад эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах “Сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээ”-г тусгай удирдамжийн дагуу хэрэгжүүлэх, талаар аян зохион байгуулан үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна. Люксембургийн “MEDICUS CAMPUS” төсөл, “Телемедицин MON-003” хөтөлбөрөөр эх нярай, зүрх судасны зайны оношлогоонд холбогдон зүрх судасны чиглэлээр улсын хэмжээнд 165 хүнд зөвлөгөө өгч 16 удаа дээд шатлалаас зөвлөгөө авч, 23</p>	НХХ

				<p>хүнийг дээд шатлалын эмнэлэгт сүлжээгээр цаг алдалгүй илгээн 19 өвчтөн эдгэрсэн байна. Мөн 12 аймгийн зүрх судасны эмч нарт зөвлөгөө зөвлөмжийг хүргүүллээ.. Улсын хэмжээнд зүрх судасны зайн оношлогоогоор тэргүүн байр эзэлж, Испани улсад “Зүрх судасны эмч нарын Европын нийгэмлэг”-ийн зөвлөлгөөнд оролцлоо. 2014 оны байдлаар Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 47 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 531 эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг хамрууллаа.</p> <p>/Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
19.5	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт, 21.3 дахь хэсэг</p>	<p>Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо</p>	<p>Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад “Яаралтай тусламж үйлчилгээний нэгж”-ийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375-р тушаалаар зохион байгуулж, хүлээн авах хэсэгт эрэмблэн ангилах самбарыг байршуулан, тушаалын дагуу яаралтай тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2014 оны 85-р тушаалаар яаралтай тусламж, хүлээн авах тасгийг стандартын шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, “Яаралтай тусламжийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ажиллах журам, осол гэмтэл, гамшгийн үед яаралтай тусламж үзүүлэх журам”-ыг боловсруулан мөрдөн ажиллаж байна. 2014 онд яаралтай тусламжийн тасагт 2 орыг шинээр нэмэгдүүлэн, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж,</p>	НХХ

				<p>холбоо мэдээллийн хэрэгслээр хангагдан алсын дуудлагад 6 автомашиныг байнгын бэлэн байдалд ажиллуулж, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх “С” ангиллын тоноглогдсон автомашинаар хангагдлаа.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор Яаралтай тусламж, Төрөх, эмэгтэйчүүдийн тасаг, Оношлогооны тасагт нэн шаардлагатай 744,849,306 сая төгрөгийн аппарат, тоног төхөөрөмжөөр ханган орчин үеийн оношлогоо, эмчилгээний чадамжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Аймгийн Мэс заслын тасагт “Итгэл хавдар” сангаас 23.0 сая төгрөгийн санхүүжилттэй хавдрын тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжөөр 2 өрөөг хангаж тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэн иргэдэд ээлтэй тав тухтай орчинг бүрдүүлсэн. 2014 оны байдлаар яаралтай тусламж үйлчилгээний тасагт алсын болон яаралтай тусламжийн дуудлагын цүнх, биксийг байрлуулан бэлэн байдлыг ханган ажиллаж, яаралтай тусламжийн дуудлагын үйлчилгээг 4970 хүнд үзүүлсэн ба явж үйлчилсэн 165, зөвлөгөө өгсөн 67 удаа байна.</p> <p>/Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
19.7	ЗГҮАХХАХТ-ний 167.5 дахь заалт	Эмийн чанарыг баталгаажуулах стандартыг боловсруулах	Шинэчлэн боловсруулах стандартын тоо	<p>Аймгийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах Эм ханган нийлүүлэх байгууллага 2, эмийн сан 28 ажиллаж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага болон хүн амыг нэн тэргүүнд зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй хангах бодлого чиглэл баримтлаж байна. Эм хангамжийн</p>	НХХ

				<p>байгууллагын тогтолцоог бэхжүүлэх талаар эм, биологийн идэвхт бүтээгдхүүн, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, түгээлт, зах зээл дэх эмийн чанар аюулгүй байдал, худалдах тусгай зөвшөөрлийг нийт 25 эм хангамжийн байгууллагад шалгаж, эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсад 2920 эм бэлдмэл бүртгэлтэй байгаагийн 1800 гаруй нэр төрлийн эмийг оношлогоо эмчилгээнд хэрэглэж байна. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний гаж нөлөөнд тандалт судалгаа хийж, гаж нөлөө илэрсэн тохиолдол бүрийг бүртгэж мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд албан ёсоор 7 гаж нөлөө бүртгэгдсэнийг ЭМЯ-нд мэдээлж ажилласан.</p> <p>/Хэрэгжилт 90.0 хувь/</p>	
19.10	ҮХЦБ-ын 4.5 дахь заалт	“Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>Хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу албан байгууллага аж ахуйн нэгжүүд “Эрүүл ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих, ажилтан албан хаагчдыг халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэдлэг, хандлагыг өөрчлөх чиглэлээр хамтран ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 28 байгууллагын 719 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, албан хаагчдад “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”, “Зөв зохистой хооллолт”, “Ажлын</p>	НХХ

			<p>байрны стресс менежмент” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулан, зөвлөгөө, зааварчилгааг өгч ажилласан. “Эрүүл мэндийг дэмжигч ажлын байр”-ны тоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох” болзолт уралдаан-22, өдөрлөг, уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил-18, ажил мэргэжлийн уралдааныг- 8 удаа, “ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх” сургалтуудыг 36 удаа зохион байгуулж нийт давхардсан тоогоор 75448 хүнийг хамруулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллаа. Айл өрх, албан байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуй, амьдралын нөхцлийг дээшлүүлсэн, ундны усны найдвартай эх үүсвэртэй, хүнсний аюулгүй байдлыг хангасан оршин суугчдад нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгоор зарласан болзолт уралдаанд 72 байгууллага, айл өрх оролцсоноос айл өрхийн 30%, албан байгууллагын 60% нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон байна. Худаг усан сангийн орчны эрүүл ахуйн халдваргүйтгэлийг гэрээний дагуу хийж гүйцэтгэн, усаа хэрхэн зөв хадгалах, зөөвөрлөх талаар усан санч нар болон иргэдэд 46 удаа сургалт зохион байгуулж, 3874 иргэнийг хамруулж, зөвлөмж гарын авлагыг 2987 иргэнд тараасан байна. Ундны усны эрүүл ахуйн талаар иргэдийн мэдлэг 4.3%-иар нэмэгдлээ. Аймгийн төвийн 6 худаг болон усан санд ундны усны чанар, аюулгүй байдлын талаар мэдээллийн самбар байршуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн</p>	
--	--	--	---	--

				ажиллаж байна. Аймгийн хэмжээний эрүүл мэндийн байгууллагууд “ЭКО хүнс” үзэсгэлэн худалдааг 6 удаа зохион байгуулж, 5174 иргэнийг хамруулан, 2731 ширхэг гарын авлага тараасан. /Хэрэгжилт 90.0 хувь/	
Зорилт 20.Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.					
20.1	Соёлын тухай хуулийн 13.1.4 дэх заалт	Хөдөө орон нутгийн соёлын төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих	Соёл, урлагийн байгууллагын тоо	Булган аймагт 16 сум 1 тосгон, ХЖТ, АТНС, Аймгийн Музей үйл ажиллагаа явуулж иргэдэд соёл, урлагийн үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн ХЖТ-т 278 сая төгрөгийн их засварыг Орхон аймгийн “Сэхүүн чоно” барилгын компани гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.ХЖТ-ийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэх саналыг олон компанид хүргүүлээд байна. Аймгийн төв номын сангийн өргөтгөлийн барилгын 671 сая төгрөгийг 2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгаж шийдвэрлэсэн. Бүрэгхангай сумын соёлын төвийн барилгын их засварыг 190,0 сая төгрөг, Рашаант сумын соёлын төвийн барилгын засварт 150,0 сая төгрөг, Дашинчилэн сумын соёлын төвийн засварт 120 сая төгрөгийг шийдүүлж гүйцэтгэчийг сонгон шалгаруулж засварын ажлыг хийж дуусгалаа. Баяннуур 239.400.000, Хангал 90.253.845, Гурванбулаг 119.991.622, Сайхан 84.400.000 сая, Хутаг-Өндөр 110.434.851 төгрөгний барилгын засварын зургуудыг хийлгүүллээ. Сумдын соёлын төвүүд, ХЖТ-ыг орчин үеийн техник хэрэгсэлээр хангахаар ССАЖЯ-нд санал хүргүүлсэнээр Хөгжимт жүжгийн театр, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Баяннуур, Хангал, Хялганат, Хишиг-Өндөр, Орхон сумдад 51,470,080 сая	НХХ

				<p>төгрөгний дууны тоног төхөөрөмж, Баяннуур, Хангал сумдад Морин хуур, ятга, шанз, хуучир, ёочин, лимбэ зэрэг 6,919,111 төгрөгний үндэсний хөгжим, Бугат, Орхон суманд үзэгчдийн сандал 401 ширхэг буюу 13,649,420 төгрөг, Бүрэгхангай, Хутаг-өндөр, Тэшиг, Бугат, Баяннуур, Могод, Орхон, Хангал, Хишиг-өндөр, Баян-Агт, Сэлэнгэ сумдад номын сангийн тавиур, тогтмол хэвлэлийн тавиур, катологийн шүүгээ зэрэг 30,337,000 төгрөгний хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангаас Рашаант сум 12 сая, Булган сумын соёлын ордон 15 сая төгрөгний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт нийт 129.375.611 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдлээ.</p> <p>/Хэрэгжилт 100.0 хувь/</p>	
20.2		Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>2014 онд “Соёлын өвийг хамгаалах тухай” хууль батлагдаж, Соёлын өв хамгаалах эрх зүйн орчин, соёлын өвийн босоо тогтолцоо бүрдэж, Соёлын өвийн бүртгэл мэдээлэл, хяналтын нэгдсэн системтэй боллоо. Соёлын биет болон биет бус өв тээгчийн судалгааг гаргаж Соёлын өвийн төвтэй хамтран соёлын биет бус өв болох Могод сумын иргэн тэнгэрээр шинжээч П.Банзрагч, Хангал сумын иргэн уртын дууны төрөлд н.Сандагсүрэнг цахим бүртгэлд, Г.Нямганжав сур, малын арьс шир боловсруулах, уламжлалт сур хийх аргыг судлан 2 хүнийг, Эсгийн эдлэлээр 2 хүнийг, хамт олонд түшиглэсэн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн ажлыг анх удаа эхлүүлж үндэсний шагайн харвааны үлэмж дархан мэргэн Г.Нинжпэрэнлээ болон түүни баг хамт олныг хамрууллаа. Нийт 12 өвийг шинээр өвлөн уламжлагчийн цахим</p>	НХХ

			<p>бүртгэлд бүртгэж авлаа.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэр дээр нийт 1802 Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл бүртгэгдсэнээр улсын хамгаалалтанд 11 аймгийн хамгаалалтанд 25 байна.</p> <p>2013 онд 5 дурсгалт газрыг хашаажуулан хамгаалалтанд авч, 2014 онд 10 орчим сүмийн туурь, дурсгалт газрыг шинээр нээн илрүүлж бүртгэл мэдээллийн санд бүртгэлээ.</p> <p>Бугат сумын Цачирт,Уулын голын сав дагуух дурсгал булш хиргисүүрүүдийг ухаж тоносон байгааг иргэдийн мэдээллээр шалгаж баталгаажууллаа.</p> <p>Хангал сумын Сүмийн нуга гэдэг газраас 1930-иад оны үед байсан сүмийн туурь, түүнийг дагалдах шавар цутгамал бурхануудыг илрүүлж сумын хамгаалтанд авсан. Баян-агт сумын Шарга багийн Цагаан олом хэмээх газар буй “Буган чулуун хөшөө”-г, “Бараан толгой” хэмээх газар орших “буган чулуун хөшөөг хамгаалалтанд авч,иргэн С.Даваасүрэн,Б.Баттулга нарт хариуцуулсан байна. Баян хайрхан багийн “Тээлийн тасархай” ,”Бүүвэй баатарын балгас”-ыг гэдэг газар байрлах “Хиргисүүр”,Дулаан хан багийн нутаг Бага-Агт гэдэг газар орших “Бичигт хад,хиргисүүр,буган чулуун хөшөөг орон нутгийн хамгаалалтанд авч иргэн Б.Даваасүрэнд, Л.Намнандоржид Булган сумын зүүн түрүүний хүн чулууг, Бугат суманд Цацын хотгорын хүн чулуун хөшөөг, Могод суманд Цахиуртайн буган чулуун хөшөө 2ш,Тээг буган чулуун хөшөө 1, Дашинчилэн “зэл чулуу”, Сайхан суманд Нарийн хүрэмтийн буган хөшөө, Асган дэвсэгийн буган ч/х, Цөнгөрөгийн хөшөө чулуу, Лхавгадорж баатрын хөшөө, Хишиг-Өндөр суманд Хишиг-өндөр сумын Мөнгөн</p>
--	--	--	---

				уул хэмээх 50 га газрыг сумын тусгай хамгаалалтанд авсан Сумын төвийн арын буган ч/х , Хутаг-Өндөр суманд Гурт хүн/ч/х , Орхон суманд сумын төвийн хойд хэсэгт 7 буган хөшөө, Рашаант суманд Ар булагийн 1 х/ч/хөшөөг иргэдэд гэрээ хийн хариуцуулсан. /Хэрэгжилт 90.0 хувь/	
Зорилт 21.Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.					
21.1	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр /цаашид “БТСХЦХ” гэх/-ийн 3.4.5 дахь заалт	Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Булган аймагт багийн спортын төрлүүдийг хөгжүүлэх спортын уралдаан тэмцээнүүдэд тогтмол хөгжүүлэх зорилгоор спортын холбоодыг шинэчлэн зохион байгуулан ажиллаж түүний үр дүнд улс бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг тухайлбал 2013 оны сагсан бөмбөгийн Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээн, 2014 онд Волейболын ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулахын зэрэгцээ өсөврийн баг тамирчид Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй эмэгтэй багууд өсвөр үеийн төрөлд алтан медаль, волейболын төрөлд мөнгөн медаль хүртсэнээс гадна гандболын спорт шинээр хөгжиж улс бүсийн тэмцээнд амжилт гаргаж мини, өсвөр үеийн УАШТэмцээнээс алт хүрэл медаль хүртээд байна. Багийн спортыг хөгжүүлж тамирчдыг урамшуулж мөнгөн шагналыг олгож байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	НХХ
21.2	БТСХЦХ-ийн 3.1.16 дахь заалт	Аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, явган аяллыг хөгжүүлэх;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Явган аялалыг хөгжүүлэх талаар доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд сумдууд өөрсдийн явган аялалын чиглэл маршрут, км тогтоох ажлуудыг хийж байгаагаас гадна аймгийн төвд 2 чиглэлийн маршрутыг 10км, 5км-ээр гаргалаа. Явган	НХХ

				аялалыг нийтийг хамарсан чиглэлээр зохион байгуулан төрийн болон төрийн бус байгууллагуудыг өргөн хамруулаа. /Хэрэгжилт 70.0 хувь/	
21.3	БТСХЦХ-ийн 3.4.5 дахь заалт	Хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх	Хамрагдах аймаг, дүүрэг	Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил судалгааг жилд 2 удаа авч нийт хүн амын 3-64 насныхнаас судалгааг авч улсын цахим санд 16400 хүний материалыг шивж баталгаажуулан ажиллаж байна. Албан байгууллага, сургууль цэцэрлэгт өдрийн болон ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж холбогдох ном товхимол сд-г тарааж байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 50 чийрэгжүүлэлтийн кабинет үйл ажиллагаа явуулж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	НХХ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ					
Зорилт 22.Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.					
22.1	ҮХЦБ-ын 7.2 дахь заалт	Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх		Хүн амын мэдээллийн сан бүрэн цахимжсан, эд хөрөнгийн эрхийн болон бусад эрхийн бүртгэл цахимд шилжиж байна. Төрийн архивт мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 35 хувьтай байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	ТЗУХ
22.2	ЗГҮАХХАХТ-ний 313 дахь заалт	Эрүүгийн бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх		Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд орон нутагт Тахарын алба байгуулагдаж, Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу орон нутгийн байгууллагын бүтэц, цолонд өөрчлөлт орсныг бүрэн хэрэгжүүлсэн. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХЗХ
22.3	ҮХЦБ-ын 4.4.2 дахь заалт, Хөгжлийн стратеги хөтөлбөр	Хорих байгууллагын тогтолцоог шинэчлэх		Булган аймагт онцгой дэглэмтэй хорих 439-р анги үйл ажиллагаа явуулж байна. ШШГА-нд цагдан хорих байх ажиллаж байгаа бөгөөд	ХЗХ

				2015 оноос баривчлах байрны чиг үүрэг тус албанд шилжинэ. /Хэрэгжилт 100.0 хувь/	
22.4	Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 1.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 247.3 дахь заалт	“Улсын хил хамгаалалтын техник хангамжийг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх		Улсын хил хамгаалалтанд туслах хүчний зөвлөл ажиллаж хилийн цэргийн албан хаагчдын ажиллах амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор Ангалагийн заставыг тохижуулахад 21,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн сангаас хийсэн. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХЗХ
22.5	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги, хөтөлбөрийн 4.5 дахь заалт	Хилийн шалган нэвтрүүлэх тогтолцоог шинэчлэх		Бага илэнхи айнек боомтыг байнгийн ажиллагаатай болгох талаар холбогдох газруудад санал тавьж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХЗХ
22.6		Хуулийн боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Эрх зүйн хөтөч” аймгийн хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд сум бүрт эрх зүйн сургагч багш нар бэлтгэгдэж, олон нийтэд эрх зүйн мэдээ, мэдээлэл түгээх, эрх зүйн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажиллана. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХЗХ
22.7	ЗГҮАХХАХТ-ний 306.1 дэх заалт	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх		Шүүх эрх мэдлийн цахим мэдээллийн орчин бүрэн хэрэгжсэн. Прокурор болон Цагдаагийн газар, ШШГА- дууд дээд газартай цахим хурал хийх, захиргааны зөрчил, гэмт хэргийн мэдээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт 100.0 хувь/	ХЗХ
Зорилт 23.Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.					
23.2	ЗГҮАХХАХТ-ний 267.2 дахь заалт	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи,	Инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн	2014 онд газар хөдлөлт цөмийн болон уул уурхайн тэсэлгээний бүртгэл 8112 цагийн	НХХ

		гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх	судалгааны ажил	бүртгэл мэдээ, Одон орон геофизик судалгааны төвд илгээх сейсмограмм мэдээ 8450 мбайт, газар хөдлөлтийг бүртгэх техник ажиллагааг хянах мэдээлэл 338 файлаар Үндэсний Мэдээллийн Төвд шууд горимоор дамжуулав. Төвийн Техник технологийн багийн инженер техникийн ажилчдын орон нутгийн тойролт 4 удаа ирж 12 хоногийн хугацаатай ажиллаж blgm станцын хэвийн үйл ажиллагааг шалган газар хөдлөлтийн өргөн зурвасын” Guralp станц суурилуулсан. /Хэрэгжилт 100.0 хувь/	
ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ					
Зорилт 24.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.					
24.1	ЗГҮАХХАХТ-ний 253.2 дахь заалт	Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” хөтөлбөрт Булган аймгийн Тэшиг сумын Бага илэнх, ОХУ-ын Буриад улсын Закамень аймгийн Айнек хилийн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, үүгээр дамжуулан мал мах түүхий эд гаргах зорилтыг дэвшүүлээд байна. Бага-Илэнхийн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох саналыг Засгийн газар, салбарын яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэх талаар шат дараатай арга хэмжээг авч ажиллаж байна. /Хэрэгжилт 70.0 хувь/	ТЗУХ

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 91.74 хувьтай биеллээ.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.ЭРДЭНЭБАТ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Булган аймаг

2015.01.10

№	Агуулга	Нийт заалтын тоо	Үүнээс							Тасарсан	Хувь
			Биелсэн 100	Хэрэгжих шатандаа	Үүнээс						
					90	70	50	30	10		
1	Зорилт-1. Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ.	2	2	-	-	-	-	-	-	-	100.0
2	Зорилт 4.Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.	3	2	1	1	-	-	-	-	-	96.6
3	Зорилт 6.Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ.	2	1	1	1	-	-	-	-	-	95.0
4	Зорилт 7. Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.	1	-	1	1	-	-	-	-	-	90.0
5	Зорилт 8.Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	3	1	2	1	-	-	-	1	-	66.6
6	Зорилт 9.Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	2	2	-	-	-	-	-	-	-	100.0
7	Зорилт 10. Орчны бохирдлоос хамгаалж, доройтлыг бууруулж, ногоон хөгжлийг бий болгоно.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
8	Зорилт 11.Биологийн олон янз байдлыг хамгаална.	4	2	2	1	1	-	-	-	-	90.0
9	Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.	2	-	2	1	1	-	-	-	-	80.0
10	Зорилт 13 ."Ажилтай, орлоготой Монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
11	Зорилт 15.Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
12	Зорилт 16.Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.	4	2	2	1	1	-	-	-	-	90.0
13	Зорилт 17.Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.	8	2	6	5	1	-	-	-	-	90.0
14	Зорилт 19.Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээг	5	-	5	5	-	-	-	-	-	90.0

	иргэн бүрд хүргэх боломжийг бүрдүүлнэ.										
15	Зорилт 20.Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.	2	1	1	1	-	-	-	-	-	95.0
16	Зорилт 21.Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.	3	2	1	-	1	-	-	-	-	90.0
17	Зорилт 22.Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.	7	7	-	-	-	-	-	-	-	100.0
18	Зорилт 23.Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
19	Зорилт 24.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	1	-	1	-	1	-	-	-	-	70.0
НИИТ		53	28	25	18	6	-	-	1	-	91.74

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.ЭРДЭНЭБАТ

	үйлчилгээг иргэн бүрд хүргэх боломжийг бүрдүүлнэ.												
15	Зорилт 20.Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.	2	-	1	1	-	-	-	-	-	-	-	95
16	Зорилт 21.Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.	3	-	2	-	-	1	-	-	-	-	-	90
17	Зорилт 22.Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.	7	-	7									100
18	Зорилт 23.Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	100
19	Зорилт 24.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	70
	НИЙТ	56		30	17	2	5	-	-	-	-	1	93.2